



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3, 14 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2026/05-11/ШТА-ГА) тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2027 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2027 оны 2 дугаар улиралд танилцуулахыг Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер (Ч.Болд)-д үүрэг болгосугай.

4.Тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт тус тус хүргүүлсүгэй.



Г.НАНДИНЖАРГАЛ

1428010015



Агуулга

Гарчиг	Хуудас
Товчилсон үг	2
Хүснэгтийн жагсаалт	3
Дүрслэлийн жагсаалт	3
Хавсралтын жагсаалт	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Ерөнхий мэдээлэл	5
БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ оновчтой төлөвлөсөн үү?	6-7
1.1 Төсөвлөлтийн шаардлага хангасан, өртөг, санхүүжилт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?	6-7
БҮЛЭГ 2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан уу?	8-9
2.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан уу?	8-9
2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг хянаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн үү?	8-9
БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?	10-14
3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн үү?	10-14
3.2 Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн үү?	10-14
3.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлж бүртгэн зориулалтын дагуу ашиглаж байна уу?	10-14
Аудитын дүгнэлт	15
Аудитын зөвлөмж	16
Холбогдох байгууллагын санал	17
Саналд өгсөн тайлбар	18-20
Хавсралт	21-26



Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
БС	Боловсролын сайд
ГБХНХС	Гэр бүл хүүхэд нийгмийн хамгааллын сайд
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТС	Зам, тээврийн сайд
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НЭМГ	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
ССАЖЗС	Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБХНТХНэгж	Улаанбаатар хотын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
УТ	Улсын төсөв
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХББОСС	Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд



Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	ТЕЗ-аас НЗД-д эрх шилжүүлсэн ТАХ	5
Хүснэгт 2	Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ	7
Хүснэгт 3	Худалдан авах ажиллагааны мэдээлэл	8
Хүснэгт 4	Шууд гэрээ байгуулсан ТАХ	8
Хүснэгт 5	Эрх шилжсэн ТАХ-ний санхүүжилт	10
Хүснэгт 6	Хэрэгжилт хангалтгүй ТАХ	11
Хүснэгт 7	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага	12
Хүснэгт 8	ТАХ-г данс бүртгэлд тусгасан байдал	13

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	Барьцаа хөрөнгийг байршуулсан, УТ-д төвлөрүүлсэн дүн	12

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн багцад задарсан 55 төсөл, арга хэмжээ	21-26



ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрх, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Нийслэлд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн Нийслэлийн Засаг дарга, ЗДТГ, харьяа байгууллагууд, ОНӨААТҮГ-ууд болон төсөл, арга хэмжээг гэрээгээр гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитыг Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар “Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг баталсан.

Дээрх жагсаалтад тусгагдсан ТАХ-ээс 362,741.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 137,751.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг холбогдох ТЕЗ-даас НЗД-д шилжүүлсэн байна. /Эдгээр ТАХ нь багцад задарч 55 төсөл, арга хэмжээ болсон./

Үүнээс 3 ТАХ нь багцад задарч 14 ТАХ болж 2025 онд шинээр эхлэх, 41 ТАХ нь өмнөх онуудаас он дамжин хэрэгжиж байна.

Хүснэгт 1. ТЕЗ-аас НЗД-д эрх шилжүүлсэн ТАХ

(сая.төг)

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний				Үүнээс										
						Дууссан			Он дамжих			Гэрээ байгуулагдаагүй			Тодотголоор хүчингүй болсон	
		Тоо	Багц тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг
1	БОУАӨС	2	13	50,000.0	50,000.0	4	2,286.4	2,286.4	6	18,317.7	18,317.7	3	29,395.9	29,395.9	-	-
2	БС	17	19	114,410.4	24,189.7	10	48,155.7	3,613.2	9	66,254.7	20,576.5	-	-	-	-	-
3	ГБХНХС	2	2	3,285.8	1,238.3	1	285.8	238.3	1	3,000.0	1,000.0	-	-	-	-	-
4	ЗТС	2	2	7,965.0	2,865.0	1	4,194.0	1,494.0	1	3,771.0	1,371.0	-	-	-	-	-
5	ССАЖЗС	2	2	30,571.6	9,574.1	-	-	-	2	30,571.6	9,574.1	-	-	-	-	-
6	ХББОСС	8	13	132,777.8	40,246.2	1	2,694.2	594.3	11	128,723.8	38,292.1	1	1,359.8	1,359.8	-	-
7	ЭМС	3	4	23,731.3	9,638.3	1	4,531.9	980.1	2	16,199.4	8,658.2	-	-	-	1	3,000.0
	Нийт	36	55	362,741.8	137,751.6	18	62,148.0	9,206.3	32	266,838.1	97,789.6	4	30,755.7	30,755.7	1	3,000.0

Тайлант онд дээрх ТАХ-ээс 62,148.0 сая төгрөгийн 18 ТАХ буюу 32.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 266,838.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ буюу 58.2 хувь нь он дамжин хэрэгжиж, 30,755.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ буюу 7.3 хувь нь хэрэгжиж эхлээгүй, 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ буюу 1.8 хувь нь тодотголоор хасагдсан байна.

ТАХ-ний 76.3 хувийг барилга, байгууламж, 10.9 хувийг зураг төсөв боловсруулах, 5.5 хувийг авто зам, засвар шинэчлэлт, 5.5 хувийг тоног төхөөрөмж, 1.8 хувийг их засварын ажил эзэлж байна.

ТЕЗ-даас 2024 онд НЗД-д 1,038,127.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 142 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж байсан бол 2025 онд 362,741.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж, өмнөх онтой харьцуулахад хөрөнгө оруулалтын дүн 65.0 хувиар буурсан байна.



БҮЛЭГ 1. ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ШИНЭ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 29.4, 29¹ дүгээр зүйлийн 29^{1.1}, 29^{1.2}, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11 дэх заалтууд, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлагыг тусгажээ.

1.2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹-д заасныг зөрчин 2 багц ТАХ-г нийт 50,000.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр баталсан байна. Үүнд:

- XI.1.2 Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламж /Улаанбаатар/ 8,187.9 сая төгрөг;
- XI.1.4 Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ 41,812.1 сая төгрөг.

1.3. НЗД-ын 2025 оны А/748, 749, 760, 1247, 1538 дугаар захирамжуудаар дээрх 2 багц ТАХ-г 13 ТАХ болгон задалж зураг төсөв, ажлын даалгавар, магадлалын дүгнэлтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²-д нийцээгүй байна. Үүнд:

- Багц 1 "Загвар зураг төсөв боловсруулах ажил /Улаанбаатар/;
- Багц 2 "Инженерийн дэд бүтцийн ажлын зураг боловсруулах ажил /Улаанбаатар хот/";
- Багц 3 "Гадна инженерийн шугам сүлжээний ажил, ус хангамж, ариутгах татуурга, усалгааны систем /Улаанбаатар хот/";
- Багц 4 "Цахилгаан хангамж /Улаанбаатар хот/";
- Багц 5 "Гадна холбоо /Улаанбаатар хот/";
- Багц 6 "Авто зам, зогсоолын ажлын зураг боловсруулах /Улаанбаатар хот/";
- Багц 1 "Хамгаалалтын хашаа /Улаанбаатар хот/";
- Багц 2 "Авто зам, зогсоолын ажил /Улаанбаатар хот/";
- Багц 3 "СОР 17 хурлын байр, байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл /Улаанбаатар хот/";
- Багц 4 "СОР 17 хурлын байр, байгууламжийн нэгдүгээр үе шатны ажил /Улаанбаатар хот/";
- Багц 5 "СОР 17 хурлын байр, байгууламжийн гадна гэрэлтүүлгийн кабель болон хамгаалалтын хоолойн угсралтын ажил /Улаанбаатар хот/";
- Багц 6 "СОР 17 хурлын хүлээн авагч орны байр, нийтийн ариун цэврийн байгууламжууд, болон харуул хамгаалалтын байрны ажлын зураг төсөл боловсруулах ажил;
- Багц 7 "СОР 17 хурлын байр, байгууламжийн дотор төлөвлөлт, гадна, дотор болон инженерийн хангамжийн зураг төсөл боловсруулах ажил.

1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025-2027 онд хэрэгжүүлэх 5,134.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна цахилгааны ажлын үлдэгдэл" (Улаанбаатар хот. Баянгол дүүрэг, 11-р хороо) ТАХ-ний 2025 онд санхүүжих дүнг төсвийн тодотголоор 500.0 сая төгрөгөөр баталж бууруулсан нь Төсвийн тухай хуулийн 29.3.5³, 29.3.6⁴-д нийцээгүй байна.

¹ 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

² 29.4. "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана";

³29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

⁴ 29.3.6. тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.



1.5. Өмнөх оноос хэрэгжсэн 6 ТАХ-ний санхүүжих дүнг 312.7-1,794.7 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

Хүснэгт 2. Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа			Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Тэнцүү хуваарилсан	Дутуу
		Эхлэх	Дуусах	жил				
1	Өвлийн спортын ордны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2024	2026	3	18,232.5	5,526.4	6,077.5	(551.1)
2	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2024	2025	2	12,550.6	4,480.6	6,275.3	(1,794.7)
Гандангийн дэнж шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/		2022	2025	4	23,484.9	3,044.9	5,871.2	(2,826.3)
3	Багц-1: Гадна дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын ажил, зам талбайн тохижилт, Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	2022	2025	4	13,430.4	3,044.9	3,357.6	(312.7)
4	Гадна цахилгаан хангамжийн ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	2022	2025	4	6,292.8	-	1,573.2	(1,573.2)
5	Гадна холбооны ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	2022	2025	4	1,737.2	-	434.3	(434.3)
6	Багц-4 Гудамж дундын чулуун замын зураг төсөв, барилга угсралтын ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	2022	2025	4	2,024.5	-	506.1	(506.1)
НИЙТ					54,267.9	13,051.9	18,224.0	(5,172.1)

1.6. ТЕЗ-аас НЗД-д эрх шилжүүлсэн ТАХ-үүд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, санхүүжих дүнг тэнцүү хуваарилаагүйгээс төлөвлөсөн ТАХ тухайн онд бүрэн хэрэгжихгүй, удаашрах, чанаргүй болох зэргээр ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.



БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛАХДАА ҮР АШГИЙН ТООЦОО СУДАЛГАА ХИЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. ТЕЗ-даас НЗД-д эрх шилжүүлсэн 3 багц бүхий 14 ТАХ-ний худалдан авах ажиллагааны 10 ТАХ-г шууд гэрээгээр, 1 ТАХ-г нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, 3 ТАХ-ний ХАА нь 2025 онд хэрэгжиж дуусаагүй он дамжсан байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны мэдээлэл

(сая.төг)

№	Байгууллагын нэр	ХАА-ны арга	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Шалгарсан үнэ	Хэмнэлт
1	НЗДТГ	шууд	10	24,551.9	24,528.5	23.4
2	“Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ	нээлттэй	1	1,186.7	1,102.1	84.6
НИЙТ			11	25,738.6	25,630.6	108.0

2.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын ажил /2 багц бүхий 9 ТАХ/, “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна цахилгааны ажлын үлдэгдэл ажил (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо VII бичил хороолол), нийт 10 ТАХ-ний гүйцэтгэгчтэй ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.8⁵-д заасны дагуу шууд гэрээ байгуулжээ. Үүнд:

Хүснэгт 4. Шууд гэрээ байгуулсан ТАХ

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Эрх шилжүүлсэн	Захирамжийн дугаар
1	Багц 1 “Загвар зураг төсөв боловсруулах ажил /Улаанбаатар/”	471.2	471.2	“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ	2025.05.29 А/749
2	Багц 2 “Инженерийн дэд бүтцийн ажлын зураг боловсруулах ажил /Улаанбаатар хот/”	221.8	221.8		2025.05.29 А/749
3	Багц 6 “Авто зам, зогсоолын ажлын зураг боловсруулах /Улаанбаатар хот/”	379.9	379.9		2025.05.29 А/749
4	Багц 3 “СОР 17 хурлын байр, байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл /Улаанбаатар хот/”	653.5	653.5		2025.09.22 А/1327
5	Багц 3 “Гадна инженерийн шугам сүлжээний ажил, ус хангамж, ариутгах татуурга, усалгааны систем /Улаанбаатар хот/”	3,850.3	3,850.3	“Улаанбаатар хотын Ус сүвгийн удирдах газар” ОНӨААТҮГ	2025.05.29 А/749
6	Багц 4 “Цахилгаан хангамж /Улаанбаатар хот/”	2,233.4	2,233.4	“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	2025.05.29 А/749
7	Багц 5 “СОР 17 хурлын байр, байгууламжийн гадна гэрэлтүүлгийн кабель болон хамгаалалтын хоолойн угсралтын ажил /Улаанбаатар хот/”	351.7	351.7		2025.11.04 А/1541
8	Багц 5 “Гадна холбоо /Улаанбаатар хот/”	1,031.2	1,031.2	“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК	2025.05.29 А/749
9	Багц 2 “Авто зам, зогсоолын ажил /Улаанбаатар хот/”	10,224.4	10,200.9	“Улаанбаатар зам засвар арчлал” ОНӨААТҮГ	2025.08.15 А/1127
10	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна цахилгааны ажлын үлдэгдэл	5,134.4	5,134.4	“ОСНААУГ” ОНӨААТҮГ	2025.05.30 А/768
НИЙТ		24,551.9	24,528.4		

2.3. НЗДТГ нь “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын үндсэн чиг үүрэгт хамаарахгүй “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна цахилгааны ажил”-ын гэрээг шууд байгуулсан нь төсөл арга хэмжээ удаашрах, хугацаандаа хэрэгжихгүй байх, ажлын чанар үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2.4. “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ нь шууд гэрээгээр авсан дээрх ажлыг өөрийн нөөц бололцоогоор хийх боломжгүй учир 2025 онд санхүүжих дүнд багтаан “Очирням Проперти Девеломент групп” ХХК-тай 417.8 сая төгрөгийн туслан гүйцэтгэгчийн гэрээг байгуулж, дэд станцын барилгын ажлыг гүйцэтгүүлж байна.

⁵ Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах, онцгой байдлын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний болон нийслэл хотын аж ахуй, инженер хангамжийн бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх, эсхүл хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно.



2.5. НЗД-аас “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-т эрх шилжүүлсэн “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна цахилгааны ажил” төсөл, арга хэмжээний барилга байгууламж барих ажлын туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер зохион байгуулаагүй зөрчлийг зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.6. НЗДТГ нь “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-тай 10,200.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын ажил”-ын /Авто зам, зогсоол ажил гүйцэтгэх УТ2501300845-002 дугаар/ шууд гэрээг 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр байгуулжээ.

2.7. Гэтэл “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ нь дээрх ажлыг өөрийн нөөц бололцоонд багтаан хийж хэрэгжүүлэхгүйгээр “Сотэ кашмер” ХХК-тай НЗДТГ-тай байгуулсан 10,200.9 сая төгрөгийн гэрээний дүнгээр /2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр, гэрээний № 250829/АГ-001 дугаартай/ шууд гэрээг байгуулан, гүйцэтгүүлж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 32.1⁶, 41.1⁷-т заасныг зөрчсөн байна.

2.8. Иймд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын удирдлагуудыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

2.9. Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын 1,186.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хамгаалалтын хашаа барих” ажлын худалдан авах ажиллагааг “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-аас зохион байгуулжээ.

2.10. Дээрх тендерт оролцож шалгараагүй “Жи Би Юу И Си” ХХК нь Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1⁸, 13.1.2⁹ заалтыг зөрчсөн тухай гомдлыг Сангийн яаманд гаргаж, Сангийн яамнаас гомдлыг хянан үзэж шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахгүй байх зөвлөмжийг “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-т хүргүүлсэн боловч НЗДТГ, “Гегатера тех” ХХК-ийн хооронд 1,102.1 сая төгрөгийн дүн бүхий гэрээг 2025 оны 10 дугаар сарын 22-ний өдөр байгуулсан байна.

2.11. Энэ нь санхүү төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хянасан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

2.12. НЗДТГ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь заалтыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудтай шууд гэрээ байгуулахдаа ажиллах хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадал, үр ашгийн тооцоо судалгаа хийж, төсөвт ашигтай байх тохиолдолд хэрэгжүүлж, ажиллах шаардлагатай байна.

⁶ 32.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

⁷ 41.1.1. энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан;

⁸ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална: 13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

⁹ энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох



БҮЛЭГ 3. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЭРХ ШИЛЖҮҮЛСНЭЭС ТАХ НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛ БҮРДСЭН БАЙНА.

3.1. Эрх шилжүүлэн хэрэгжсэн шинэ болон шилжин хэрэгжих 55 ТАХ-нд тайлант онд 137,751.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 28 ТАХ-ний 46,974.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож, 39,539.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

3.2. Харин тухайн жилд санхүүжих дүн төсөвт тусгагдаагүй, гүйцэтгэл гараагүй, санхүүжилт татагдсан зэрэг шалтгаанаар 51,238.3 сая төгрөгийг олгоогүй байна.

3.3. ЗГ-ын 2025 оны 231 дүгээр тогтоолоор 29,395.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 багц ТАХ-ний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулахыг даалгасан байна.

3.4. НЗД-ын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/8608 дугаартай албан бичгээр тогтоолд тусгагдаагүй 5 ТАХ-ний 10,143.5 сая төгрөгийг нэмж барьцаа хөрөнгийн дансанд байршуулах саналыг хүргүүлж, нийт 39,539.4 сая төгрөгийг байршуулсан байна.

3.5. Багцад задарсан 55 ТАХ-ээс он дамжин хэрэгжих 32 ТАХ, хэрэгжиж дууссан 18 ТАХ, гэрээ байгуулагдаагүй 4 ТАХ, тодотголоор 1 ТАХ хүчингүй болсон байна. (Хавсралт 1)

Хүснэгт 5. Эрх шилжүүлсэн ТАХ санхүүжилт

(сая.төг)

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний				Тодотголоор хүчингүй болсон		Үүнээс											
								Гэрээ байгуулагдаагүй			Гэрээ байгуулагдсан		Дууссан		Санхүүжилт				
		Тоо	Багц тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Дүн	Тоо	Барьцаа
1	БОУАӨС	2	13	50,000.0	50,000.0	-	-	3	29,395.9	29,395.9	10	20,496.2	4	2,286.4	2,286.4	9	10,220.3	8	39,539.4
2	БС	17	19	114,410.4	24,189.7	-	-	-	-	-	19	110,964.4	10	48,155.7	3,613.2	7	10,806.3	-	-
3	ГБХНХС	2	2	3,285.8	1,238.3	-	-	-	-	-	2	3,057.4	1	285.8	238.3	1	178.4	-	-
4	ЗТС	2	2	7,965.0	2,865.0	-	-	-	-	-	2	7,965.0	1	4,194.0	1,494.0	2	2,865.0	-	-
5	ССАЖЭС	2	2	30,571.6	9,574.1	-	-	-	-	-	2	30,550.9	-	-	-	1	590.9	-	-
6	ХББОСС	8	13	132,777.8	40,246.2	-	-	1	1,359.8	1,359.8	12	130,994.2	1	2,694.2	594.3	4	14,615.7	-	-
7	ЭМС	3	4	23,731.3	9,638.3	1	3,000.0	-	-	-	4	23,351.7	1	4,531.9	980.1	2	7,697.5	-	-
	Нийт	36	55	362,741.8	137,751.6	1	3,000.0	4	30,755.7	30,755.7	51	327,379.8	18	62,148.0	9,206.3	26	46,974.0	8	39,539.4

3.6. Он дамжин хэрэгжиж буй 32 ТАХ-ээс зарим ажил нь эрх шилжүүлэхдээ хугацаа алдсан, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, худалдан авах ажиллагаа оройтож зарлагдсан зэргээс шалтгаалж явц удааширсан байна. Тухайлбал:

Хэрэгжиж эхлээгүй:

Барилга угсрах талбайд шугам сүлжээ таарсан, гэрээ цуцлагдсан зэрэг шалтгаанаар 35,296.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ нь хэрэгжиж эхлээгүй байна. Үүнд:

- “Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/” 29,327.0 сая төгрөг төсөвт өртөгтэй ТАХ;
- “Цэцэрлэгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” 5,969.6 сая төгрөг төсөвт өртөгтэй ТАХ;

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй:

ТАХ-г хэрэгжүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй, газар чөлөөлөлт дуусаагүй, техникийн нөхцөл дутуу зэргээс шалтгаалан зарим ажлуудын хэрэгжилт зогссон, хийгдсэн ажлууд үр дүнгүй болох эрсдэлтэй байна. Үүнд:

- Гандангийн дэнж шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/ 4 багц ажил;
- Гадна дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын ажил, зам талбайн тохижилт, Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо);
- Гадна цахилгаан хангамжийн ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо);



- Гадна холбооны ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо);
- Гудамж дундын чулуун замын зураг төсөв, барилга угсралтын ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо).

3.7. Эрх шилжүүлэхдээ ажлын даалгавар, зураг төсөв, магадлалын дүгнэлтгүй зэргээс шалтгаалж ТАХ-г багцад задлах байдлаар худалдан авах ажиллагаа оройтож зарлагдан, тухайн ондоо амжаагүйгээс 30,755.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний гэрээ байгуулагдаагүй байна. Үүнд:

- Багц 4 “СОР 17 хурлын байр, байгууламжийн нэгдүгээр үе шатны ажил /Улаанбаатар хот” 26,378.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй;
- Багц 6 “СОР 17 хурлын хүлээн авагч орны байр, нийтийн ариун цэврийн байгууламжууд, болон харуул хамгаалалтын байрны ажлын зураг төсөл боловсруулах ажил 317.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй;
- Багц 7 “СОР 17 хурлын байр, байгууламжийн дотор төлөвлөлт, гадна, дотор болон инженерийн хангамжийн зураг төсөл боловсруулах ажил 2,699.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй;
- Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ 1,359.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй.

3.8. ЭМС-ын багцаас НЗД-д эрх шилжүүлсэн “Хавдар судлалын Үндэсний төв-II” барилга /Улаанбаатар/-ын гадна хашааны ажил 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-ний хөрөнгө татагдаж, тодотголоор хүчингүй болсон байна.

3.9. Шинээр хэрэгжүүлж буй ТАХ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, дараа онд шилжсэн байна. Тухайлбал:

Гэрээ байгуулсан боловч ажил эхлээгүй;

- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/ 572.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй;

Гэрээний хугацааг сунгасан;

- Гэрээнд заасан хугацаанд дүгнэх боломжгүйд хүрч, хугацааг сунгаж дараа онд шилжсэн 15,976.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 ТАХ байна.

Хүснэгт 6. Хэрэгжилт хангалтгүй ТАХ


(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гэрээний дүн	Ажлын явц
		Эхлэх	Дуусах				
1	Багц 1 “Хамгаалалтын хашаа /Улаанбаатар хот”	2025	2025	1,186.7	1,186.7	1,102.1	5%
2	Багц 2 “Авто зам, зогсоолын ажил /Улаанбаатар хот”	2025	2025	10,224.4	10,224.4	10,200.9	36%
3	Багц 3 “Гадна инженерийн шугам сүлжээний ажил, ус хангамж, ариутгах татуурга, усалгааны систем /Улаанбаатар хот”	2025	2025	3,850.3	3,850.3	3,850.3	46%
4	Багц 1 “Загвар зураг төсөв боловсруулах ажил /Улаанбаатар/”	2025	2025	471.2	471.2	471.2	50%
5	Багц 5 “СОР 17 хурлын байр, байгууламжийн гадна гэрэлтүүлгийн кабель болон хамгаалалтын хоолойн угсралтын ажил /Улаанбаатар хот”	2025	2025	351.7	351.7	351.7	60%
НИЙТ				16,084.3	16,084.3	15,976.3	39.4 %

3.10. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний үлдэгдэл санхүүжилтийг барьцаа дансанд төвлөрүүлж, он дамжуулан гүйцэтгэлээр олгож байна. Тухайлбал:



Дүрслэл 1. Барьцаа хөрөнгийг байршуулсан, УТ-д төвлөрүүлсэн дүн



3.11. Нийслэлийн барьцаа хөрөнгийн данснаас 2,133.7 сая төгрөгийг илүү татсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- СЯ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу НЗДТГ-аас барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийг буцаан төвлөрүүлсэн боловч ТАХ бүрээр тооцоо нийлээгүйгээс өмнө нь төвлөрүүлсэн 2 ТАХ-ний 199.3 сая төгрөг, гүйцэтгэлээр чөлөөлсөн 4 ТАХ-ний 210.7 сая төгрөгийг Улсын төсөвт давхардуулан татсан;
- Нийслэлийн дотоод аудитын албанаас тогтоосон төлбөрийн актын 338.3 сая төгрөг;
- Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 3 ТАХ-ний дүнгээс илүү 0.7 сая төгрөг;
- НХОГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй 2 ТАХ-ний 1,331.2 сая төгрөг;
- ЗГ-ын тогтоолоор барьцаа хөрөнгийн дансанд аваагүй 2 ТАХ-ний 53.4 сая төгрөг.

3.12. НЗД-д эрх шилжүүлэн хэрэгжиж буй барьцаа хөрөнгийн данснаас санхүүжүүлсэн, багцад задарсан 569,558.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг дараах байгууллагууд хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 7. Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага

(сая.төг)

№	Байгууллага	Төсөл, арга хэмжээ				Түүвэрт хамруулсан	
		Тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Санхүүжүүлсэн дүн	ТАХ тоо	Хувь
1	НБГ	3	3,964.6	1,164.6	1,164.6	3	100.0
2	НЗХГ	9	36,284.1	23,518.8	13,589.6	9	100.0
3	НХОГ	79	469,504.9	123,497.7	56,872.3	45	57.0
4	НЭМГ	3	2,394.0	1,213.3	1,213.3	2	66.7
5	СХД	3	19,011.0	1,820.0	1,820.0	1	33.3
6	УБХНТХНэгж	4	38,400.0	38,400.0	31,179.1	-	-
НИЙТ		101	569,558.6	189,614.4	105,838.9	60	59.4

3.13. Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ-ний 59.4 хувийг түүвэрт хамруулан, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/ ТАХ-ний газар чөлөөлөлттэй холбоотойгоор зураг төсөв өөрчлөгдөж сургуулийн барилга барилгажилтын талбайгаас урагш болсон, газрын халаалтын зуух газар чөлөөлөөгүй айлтай ойртсон, явган зам суулт өгсөн, хөтөвч хавтан буруу суугдсан, спорт заал дулаан алдалттай;
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 42 дугаар хороо/ ТАХ-ний хана цууралт өгсөн, хүйтний улиралд шал хийсэнтэй холбоотой шалны хулдаас хөөлттэй;
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 40 дүгээр хороо/ ТАХ-ний ажил удаашралтай, олон удаагийн ажил эрчимжүүлэх албан шаардлага өгч, гэрээ цуцлах шийдвэр гарсан ч гүйцэтгэгч Энигма констракшн ХХК талбай дээр барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн явуулсан;



- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ ТАХ-ний спорт заалны тааз зураг төсөв зохиогчийн алдаанаас болж намхан болсон тул Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар буцаан буулгалтын ажил хийгдэж таазыг өндөрлөсөн;
- Өрхийн эрүүл мэндийн барилга (Улаанбаатар, Багануур дүүрэг, 4 дүгээр хороо, "Энх-Өрх" өрхийн эмнэлэг) ТАХ-ний техникийн нөхцөл гарсан боловч гадна шугам сүлжээний ажил иргэний газар дээгүүр явахаар болсон тул зөвшилцөлд хүрэхгүй ажил удааширсан;
- Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/ ТАХ-ний үлдэгдэл хөрөнгийг улсын төсвийн хөрөнгөгүйгээс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн.

Батлагдсан зураг төсөвт өөрчлөлт оруулсан:

- ХББОСС-ын багцын Ногоон байгууламж бүхий орчны тохижилт (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг) 12,550.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, 2024-2025 онд нийт 16 байршилд хэрэгжих ТАХ нь 10 байршилд хэрэгжсэн, 1 байршилд хэрэгжиж байгаа, 5 байршилд хэрэгжиж эхлээгүй байна.

3.21. ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журамд тусгагдсан үе шатны ажлуудад холбогдох газруудаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, үүрэг даалгаврыг биелэлтийг хянаж ажилласан байна. Захиалагчийн хяналтын тайланд ил далд ажлыг фото зургаар баталгаажуулж, үүрэг даалгаврын биелэлтийг тусгасан байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн 55.6 хувийг өмчид бүртгээгүй байна.

3.22. УТХО-аар НЗД-д эрх шилжүүлэн хэрэгжих 55 ТАХ-ээс 18 ТАХ буюу 32.7 хувь нь тайлант онд бүрэн хэрэгжсэн байна.

3.23. Хэрэгжиж дууссан 61,814.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 18 ТАХ-ээс 35,300.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 ТАХ буюу 38.9 хувийг өмчийн бүртгэлд тусгасан байна.

3.24. Харин 23,819.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 10 ТАХ буюу 55.6 хувийг өмчийн бүртгэлд тусгаагүй, 2,694.2 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 1 ТАХ нь хөрөнгө оруулалтын бус шинж чанартай тул шууд зардалд тусгасан байна.

Хүснэгт 8. ТАХ-г данс бүртгэлд тусгасан байдал

(сая.төг)

№	Ангилал	Хөрөнгөнд бүртгэх ТАХ		Бүртгэсэн ТАХ		Шууд зардалд тусгасан		Бүртгээгүй ТАХ	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
1	Барилга	9	48,755.0	4	31,335.5	-	-	5	17,419.5
2	Авто зам, зам засвар	1	4,194.0	-	-	-	-	1	4,194.0
3	Техник, тоног төхөөрөмж	3	3,964.6	3	3,964.6	-	-	-	-
4	Тохижилт, их засвар	2	3,645.3	-	-	1	2,694.2	1	951.1
5	Зураг төсөв, ТЭЗҮ	3	1,255.2	-	-	-	-	3	1,255.2
Нийт		18	61,814.0	7	35,300.1	1	2,694.2	10	23,819.8

3.25. Хөрөнгөд бүртгээгүй 23,819.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 10 ТАХ-ний ажлын эцсийн гүйцэтгэл тухайн ондоо багтаж гараагүй, ажил дууссан ч хүсэлт хүргүүлээгүй зэргээс шалтгаалж өмчид бүртгэгдээгүй байна. Энэ нь Төрийн болон



орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2¹⁰-г заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

Тухайн ондоо амжаагүй:

- Багц 5 “Гадна холбоо /Улаанбаатар хот/”;
- Авто зам авто зогсоол /Улаанбаатар, Багануур дүүрэг 1, 3 дугаар хороо/;
- Багц 2 “Инженерийн дэд бүтцийн ажлын зураг боловсруулах ажил /Улаанбаатар хот/”;
- Багц 6 “Авто зам, зогсоолын ажлын зураг боловсруулах /Улаанбаатар хот/”;
- Багц 3 “СОП 17 хурлын байр, байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл /Улаанбаатар хот/”;
- Эрт илрүүлэг, оношилгооны төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/.

Өмчид бүртгүүлэх хүсэлтээ өгсөн:

- Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/
- Цэцэрлэг, сургуулиудын гадна талбайн тохижилт, ногоон байгууламж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/
- Ахмадын хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/

3.26. Өмчид бүртгэх боломжгүй 2,694.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г шууд зардлаар бүртгэсэн байна. Үүнд:

- Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 2, 30, 31 дүгээр байр/.

3.27. Аудитын явцад өмчийн бүртгэлд тусгуулах хүсэлт өгсөн 13,419.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 4 ТАХ-г НИТХ-ын 2026 оны 26/10 тоот тогтоолоор нийслэлийн өмчид бүртгүүлж залруулсан.

3.28. ТАХ-г хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын судалгааг бүрэн хийгээгүйгээс Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороонд баригдсан 1,891.9 сая төгрөгийн өртөгтэй 50 ортой цэцэрлэг хамрагдах хүүхдийн тоо цөөн шалтгаанаар ашиглалтгүй байна.

3.29. НТАГ-аас 2025 онд гүйцэтгэсэн “Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” аудитаар Нийслэлийн Засаг дарга, бөгөөд Улаанбаатар хотын захирагчид “төлөвлөлт, худалдан авалттай холбоотой” 1, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т “захиалагчийн хяналттай холбоотой” 1, нийт 2 зөвлөмж өгсөн.

3.30. Мөн Чингэлтэй дүүргийн засаг даргад 3, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргад 1, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын албан хаагчтай холбоотой сахилгын шийтгэл 1, нийт 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.31 Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг НЗДТГ болон холбогдох байгууллагуудаас ирүүлсэн хэдий ч төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-нд ХАА зохион байгуулахдаа хууль журмын дагуу үр ашгийн тооцоо судалгаагүйгээр шууд гэрээ байгуулсан, гэрээний биелэлтийг бүрэн хангуулаагүй зэрэг зөрчлүүд дахин давтан гаргасан байна.

¹⁰ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас Нийслэлийн Засаг Даргад эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 14 төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, санхүүжих дүнг тэнцүү хуваарилаагүй байна.
2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулахдаа үр ашгийн тооцоо судалгаа хийгээгүй, төсөвт ашигтай байх зарчмыг баримтлаагүй нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нь нэмэгдэх зэрэг эрсдэлийг бий болгож байна.
3. Сангийн яамнаас тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хянаж, гэрээ байгуулахгүй байх чиглэл өгсөн боловч Нийслэлийн Засаг даргын Тамгын газар гэрээ байгуулсан байна.
4. Зарим орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг өөрийн нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгээгүй, туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа холбогдох хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.
5. Төсөл, арга хэмжээ бүрээр тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс нийслэлийн барьцаа хөрөнгийн данснаас 2,133.7 сая төгрөгийг улсын төсөвт илүү татсан байна.
6. Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний үе шатны ажлуудад холбогдох газруудаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, үүрэг даалгаврын биелэлтийг хянаж ажилласан хэдий ч сайжруулах шаардлагатай байна.
7. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг өмчийн бүртгэлд тусгах талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Өмчийн харилцааны газар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.
8. Өмнөх аудитаар өгсөн *“төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх”* зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГАД:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад хүлээсэн авсан барилга байгууламжийг өмчийн бүртгэлд тусгах асуудлыг шуурхай шийдвэрлэх.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шууд гэрээ байгуулахдаа үр ашгийн тооцоо судалгаа хийх, төсөвт ашигтай байх зарчмыг баримтлах;
2. ОНӨААТҮГ-ын чиг үүрэгт хамаарах ТАХ-ний эрхийг шилжүүлэх, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх, гэрээ байгуулах явцад хяналт тавих;
3. Тайлант онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрээр тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх;
4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх.

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ:

1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАРТ:


1. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг өмчийн бүртгэлд тусгах ажлыг шуурхай зохион байгуулах.

“УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ, “ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР” ОНӨААТҮГ-т:

1. НЗД-аас эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнд туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа холбогдох хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.05.04 № 03/2772
тантай _____ -ны № _____ -т

Нийслэл дэх Төрийн Аудитын
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Нийслэл дэх Төрийн Аудитын газраас "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, дараах саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ДАРГА  Т.ОЮУНЧИМЭГ

С:\2026 олонбэн бичиг\Тамгын газар А5.docx
1726191939



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас аудитын тайлангийн төсөлтэй танилцаж Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд дараах 2 саналыг ирүүлсэн байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 14 төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, санхүүжих дүнг тэнцүү хуваарилаагүй байна.

Санал: Төсвийн тухай хуулийн цагалбарын дагуу Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн төсөлд нийслэлийн зүгээс тухайн оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор холбогдох саналаа жил бүр ТЕЗ-д хүргүүлж, ТЕЗ нь үнэлгээ хийж, эрэмбэлэн сонгож Сангийн яаманд хүргүүлдэг.

Иймд Улсын төсвийн хөрөнгөөр тухайн онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг салбарын сайд болон Сангийн яам төлөвлөн хэлэлцүүлж батлуулдаг.

Нийслэлийн зүгээс Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу төсвийн төсөлд тусгах саналыг хуулийн хугацаанд жил бүр хүргүүлэн ажиллаж байна.

Мөн салбарын сайд нараас Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний тушаалын хэрэгжилтийг ханган ажилласан.

Хариу тайлбар: Дээрх ирүүлсэн санал нь зарчмын хувьд зөрүүгүй бөгөөд “Төсвийн ерөнхийлөн захирагчдаас Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 14 төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, санхүүжих дүнг тэнцүү хуваарилаагүй байна” гэсэн дүгнэлтийг хэвээр үлдээлээ.

2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулахдаа үр ашгийн тооцоо судалгаа хийгээгүй, төсөвт ашигтай байх зарчмыг баримтлаагүй нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нь нэмэгдэх зэрэг эрсдэлийг бий болгож байна.

- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна цахилгааны ажлын үлдэгдэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо VII бичил хороолол/

Санал: Дээрх төсөл, арга хэмжээ нь Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 25 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргад эрх шилжсэн боловч, уг тушаал нь албан бичгээр 2025 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр системээр бүртгэгдэн ирсэн.

Тушаалыг үндэслэн “Эрх шилжүүлэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/567 дугаар захирамжаар НХААГ-т худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэн, нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авах ажиллагааг 1 удаа зарлан 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр нээн үнэлэхэд шаардлага хангасан оролцогч санал ирүүлээгүй тул амжилтгүй болсон.



Цаашид нээлттэй тендер шалгаруулалтын журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор гэрээ байгуулах боломжгүй нөхцөл үүссэн.

Тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр Баянгол дүүргийн 11, 22 дугаар хороонд хэрэгжиж буй гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 3720 айлын орон сууц, 1920 хүүхдийн суудалтай 2 сургууль, мөн 640 ортой 2 цэцэрлэг барих боломж бүрдэх юм.

Иймд төсвийн хөрөнгө татагдах эрсдэл үүссэн тул батлагдсан төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор Нийслэлийн орон нутгийн өмчит байгууллагад эрх шилжүүлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.8 дахь заалтыг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан болно.

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт /Улаанбаатар/

Санал: Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоолоор эрх шилжин НЗД-ын 2025.01.10-ны өдрийн А/26 дугаар захирамжаар НХААГ-т эрх шилжүүлсэн бөгөөд үүний дараагаар чиг үүргийн байгууллага болох Нийслэлийн "КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар" ОНӨААТҮГ нь Үндэсний хороонд 2025.05.05-ны 03/2814 дугаартай албан бичгээр хандаж, тус төсөл, арга хэмжээг багц болгон задлах, тус бүрийн судалгаа тооцооллыг гаргаж зөвшилцсөн. Дээрх зохион байгуулалтын үйл явцын улмаас эрх шилжүүлэх, зохион байгуулалт удааширсан.

Цаашид нээлттэй тендер шалгаруулалтын журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тухайн жилийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор гэрээ байгуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн.

Үүний дараагаар Монгол Улсын төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/656 дугаар тушаалаар тус төсөл, арга хэмжээ нь 2 багц болон эрх шилжиж ирсэн.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн талуудын бага хурлын 17 дугаар чуулган нь 2026 оны 08 дугаар сарын 16-28-ны хооронд 12 хоногийн хугацаатайгаар зохион байгуулагдах юм.

Тус батлагдсан төсөл, арга хэмжээ тус бүр нь уг хурлыг зохион байгуулах талбарын суурь дэд бүтэц, зохион байгуулалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх нэн шаардлагатай ажлууд юм. Иймд Олон улсын хэмжээний хурлыг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх, төсвийн хөрөнгө татагдах эрсдэл үүссэн тул батлагдсан төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор Нийслэлийн орон нутгийн өмчит байгууллагад тус тус эрх шилжүүлэн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.8 дахь заалтыг баримтлан зохион байгуулсан.

Мөн "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын 2026 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 01/576 тоот албан тоотоор аудитын дүгнэлттэй холбогдох саналыг НЗДТГ-т хүргүүлсэн байна. Тус албан бичигт ... БА-3.5 нь Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт, БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна



шугам сүлжээний угсралтын ажил үйлчилгээний төрөлтэй байна. Хүний нөөцийн хувьд 2000 гаруй ажилтантай үүнээс цахилгаан хангамжийн инженер мэргэжилтэй 25 ажилтан, 100 гаруй цахилгаанчин одоогоор ажиллаж байна. Иймд барилгын ажлаас бусад ажлыг өөрийн хүч, нөөц бололцооны дагуу бүрэн гүйцэтгэх боломжтой гэсэн саналыг ирүүлсэн байна.

Хариу тайлбар: НЗДТГ болон Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын ирүүлсэн саналыг үндэслэн “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна цахилгааны ажил”-ын барилга байгууламж барих үлдэгдэлд туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер зохион байгуулаагүй зөрчлийг зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

ХАВСРАЛТ

Хавсралт 1.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн багад задарсан 55 төсөл, арга хэмжээ

(сая.төг)

№	Захиалагчийн нийгэмлэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	ЗГ-ын тогтоолоор барьцаа дансанд байршуулсан	Ажлын явц	Тайлбар
				Эхлэх	Дуусах							
1	НХОГ	Бага сургуулийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, 4 дүгээр сургууль/	Барилга байгууламж	2024	2026	3,880.0	2,616.3	3,880.0	2,616.3	-	67%	Газар шороо, суурийн ажил, зoorь, 1 дүгээр давхрын каркас, гадна цахилгааны ажлууд хийгдсэн. Каркасны ажил дуусаж, гадна ханын өрлөг, гадна ус хангамж, ариутгах татуурга, гадна цахилгаан, гадна холбоо дохиоллын ажлууд хийгдсэн.
2	НБГ	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/-цахим	Тоног төхөөрөмж	2024	2025	1,512.0	12.0	1,512.0	12.0	-	100%	Тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.
3	НБГ	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/-цахим	Тоног төхөөрөмж	2024	2025	153.1	153.1	153.1	153.1	-	100%	Тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.
4	НБГ	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/-цахим	Тоног төхөөрөмж	2024	2025	2,299.5	999.5	2,299.5	999.5	-	100%	Тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн.
5	НХОГ	Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад насанд зориулсан хөгжлийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хороо/	Барилга байгууламж	2024	2026	3,000.0	1,000.0	2,771.6	-	-	5%	Гэрээ байгуулагдсан. Санхүүжилт олгогдоогүй.
6	НЗХГ	Авто замын шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 2, 3, 4, 17, 18, 19 дүгээр хороо/	Авто зам	2024	2026	3,771.0	1,371.0	3,771.0	1,371.0	-	36%	Замын хучилт хийх, явган хүний зам тавих ажил хийгдэж байна.
7	НЗХГ	Авто зам авто зогсоол /Улаанбаатар, Багануур дүүрэг 1, 3 дугаар хороо/	Авто зам	2024	2025	4,194.0	1,494.0	4,194.0	1,494.0	-	100%	Багануур АЗЗА ТӨХК-ийн нэр Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК Багануур дүүрэг дэх салбар болж өөрчлөгдсөн. Ажил хэрэгжиж дууссан.
8	НХОГ	Өвлийн спортын ордны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Барилга байгууламж	2024	2026	18,232.5	5,526.4	18,232.5	-	-	29%	3 блокторой, А блокийн багана, хана шатлалтай хэсгийн арматурчлал, хэв хашмал, В блокийн зoorь болон 1-р давхрын шатлалтай хэсгийн ажлууд, С блокийн арматурчлал болон цутгалтын ажлууд хийгдэж байна. 2025 онд санхүүжилт олгогдоогүй.
9	НХОГ	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	Барилга байгууламж	2024	2025	12,550.6	4,480.6	12,550.6	4,081.8	-	61%	Нийт 16 байршилд тохижилтын ажил хийгдэж байна.



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

№	Захиалагчийн нийгэмлэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	ЗГ-ын тогтоолоор барьцаа дансанд байршуулсан	Ажлын явц	Тайлбар
				Эхлэх	Дуусах							
10	НХОГ	Ногоон гудамж, дэд бүтэц /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	Барилга байгууламж	2024	2025	2,898.2	1,898.3	2,898.2	1,879.1	-	99%	Ажил хийгдэж дууссан.
11	НХОГ	Соёлын ордны барилга, 850 суудал /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1 дүгээр хороо/	Барилга байгууламж	2024	2026	12,339.1	4,047.7	12,318.4	590.9	-	5%	Ажлын магадлал 14,884,024,801 төгрөгөөр, барилгын материалын үнийн өсөлтийн зөрүү 3,851,591,464 төгрөгөөр тус тус батлагдсан. Үүнээс 6,600,000,000 төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвөөс олгосон бөгөөд 1 дүгээр давхрын дам нурууны ажил хийгдэж байна.
12	НХОГ	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл урс" төвийн барилга, 80 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Барилга байгууламж	2024	2026	14,587.7	8,118.7	14,587.7	6,717.4	-	74%	Барилгын бетон аргат бүгээц, гадна өрлөг, фасад дулаалга, метал фасадын ажил, дотор шавардлага, цагаан замаскийн ажил хийгдсэн. Плита, чулууны ажил хийгдэж байна. Дотор гэрэлтүүлгийн монтаж, дотор хамар хана, агааржуулалтын хоолой угсрах ажил, дотор шугам сүлжээний ажлууд, гадна цахилгаан ТП-ний барилга, лифт хийгдсэн. Хана, хамар хана, дээвэр, шал, хаалга цонх, дотор гадна засал, халаалт агаар сэлгэлт, шөвөр бохир ус, гэрэлтүүлэгч хучит төхөөрөмж, холбоо дохиолол, дотор гэрэлтүүлэг, 0.4 кв-н ЦДШ, 6 кв-н ЦДАШ, дизель генератор таах, дэд өртөөний ажлууд хийгдсэн. Тухайн жилд санхүүжилт олгогдоогүй.
13	НХОГ	Өрхийн эрүүл мэндийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг, 4 дүгээр хороо, "Энх-Өрх" өрхийн эмнэлэг/	Барилга байгууламж	2024	2026	1,611.7	539.5	1,611.7	-	-	65%	
14	НХОГ	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г.д Ø 800-ийн гол шугамыг Ø 1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулавар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Барилга байгууламж	2014	2025	30,082.4	6,295.0	30,082.4	-	-	70%	Техник импортын урд талаас 25 дугаар эмийн сангийн уулавар хүртэл 1.6 км трасот дулааны худаг, ул хөдлөхийн бетон эдлэлүүдийн цутгалт, сувгийн ажил хийгдсэн. Шугам угсралт, буцаан булалтын ажил хийгдсэн. Тухайн жилд санхүүжилт олгогдоогүй.
15	НХОГ	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г.д Ø 800-ийн гол шугамыг Ø 1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулавар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Барилга байгууламж	2014	2025	9,573.3	9,573.3	9,149.6	8,106.6	-	89%	Ажил дуусаж, комиссын акт баталгаажсан. НТ-ийн ажлын хүрээнд ажил давхацсан тул явган замын санхүүжилт олгогдоогүй.



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

№	Захиалгын нийлэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	3Г-ын тогтоолоор барьцаа дансанд байршуулсан	Ажлын явц	Тайлбар
				Эхлэх	Дуусах							
16	НХОГ	Багц-1: Гадна дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын ажил, зам талбайн тохижилт, Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	Барилга байгууламж	2022	2025	13,430.4	3,044.9	13,430.4	-	-	19%	Туулын 13-н гудамжны бохир усны шугамын ажил хийгдсэн. Тухайн жилд санхүүжилт олгогдоогүй.
17	НХОГ	Гадна цахилгаан хангамжийн ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	Барилга байгууламж	2022	2025	6,292.8	-	6,292.8	-	-	36%	10кв-ийн 1 ширхэг хуваарилах байгууламжийн барилга заслын ажлууд болон дотор тоног төхөөрөмж болох таслуур, трансформатор, дотоод хэрэгцээний төхөөрөмжүүд, хоргууд суурилуулах угсрах хөлбөх ажлууд хийгдэж байна.
18	НХОГ	Гадна холбооны ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	Барилга байгууламж	2022	2025	1,737.2	-	1,737.2	-	-	52%	Орхоны 8,20-р гудамж, Туулын 3-р гудамжны угсралтын ажлын гудамжнуудын худал сувагчгалын ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж байна.
19	НХОГ	Багц-4 Гудамж дундын чулуун замын зураг төсөв, барилга угсралтын ажил (Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	Барилга байгууламж	2022	2025	2,024.5	-	2,024.5	-	-	5%	Гэрээ байгуулагдсан. Санхүүжилт олгогдоогүй.
20	НХОГ	Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/	Барилга байгууламж	2019	2025	9,678.7	-	9,678.7	-	-	100%	Ажил хийгдэж дууссан.
21	НХОГ	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/	Барилга байгууламж	2019	2025	8,668.3	715.0	8,668.3	-	-	82%	Дотор заслын ажил хийгдэж байна. Тухайн жилд санхүүжилт олгогдоогүй.
22	НХОГ	Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/	Барилга байгууламж	2021	2025	21,387.3	4,912.1	18,475.3	-	-	85%	Ажил хийгдэж дууссан. Тухайн жилд санхүүжилт олгогдоогүй.
23	НХОГ	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг, 3 дугаар хороо/	Барилга байгууламж	2022	2025	6,730.7	3,230.8	6,730.7	2,426.9	-	88%	Халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир усан хангамж, гэрэлтүүлгийн ажил хийгдэж байна.
24	НХОГ	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	Барилга байгууламж	2018	2025	4,217.9	582.5	3,625.7 208.4 572.9	- - -	-	5%	Нэмэлт гэрээ байгуулагдсан.
25	НХОГ	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Олимп хотхон/	Барилга байгууламж	2022	2025	17,927.1	1,797.3	17,927.1	1,754.1	-	100%	Комиссын акт баталгаажих ажил бүрэн дууссан.
26	НХОГ	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 31 дүгээр сургууль/	Барилга байгууламж	2022	2025	5,239.3	30.8	5,239.3	-	-	100%	Комиссын акт баталгаажих ажил бүрэн дууссан.



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

№	Захиалагчийн нийгэмлэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	3Г-ын тогтоолоор барьцаа дансанд байршуулсан	Ажлын явц	Тайлбар
				Эхлэх	Дуусах							
27	НХОГ	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 200 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 198 дугаар цэцэрлэг/	Барилга байгууламж	2022	2025	4,984.8	-	4,984.8	-	-	100%	Комиссын акт баталгаажих ажил бүрэн дууссан.
28	НХОГ	Насан туршийн боловсролын төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21, 27 дугаар хороо/	Барилга байгууламж	2022	2025	3,184.3	-	3,184.3	-	-	100%	Комиссын акт баталгаажих ажил бүрэн дууссан.
29	НХОГ	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 40 дүгээр хороо/	Барилга байгууламж	2022	2025	5,695.3	2,841.3	5,695.2	-	-	7%	Тухайн жилд санхүүжилт олгогдоогүй.
30	НХОГ	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 42 дугаар хороо/	Барилга байгууламж	2022	2025	5,654.9	2,885.1	5,654.9	2,196.3	-	88%	Гадна металл болон шилэн фасад хийгдсэн. Гадна цэвэр бохир усны шугамын угсралтын ажил хийгдэж, дотор хаалга суулгасан. Дотор заслын ажил, шалны болон гадна тохижилтын ажил хийгдэж байна.
31	НХОГ	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	Барилга байгууламж	2022	2025	1,891.9	371.0	1,891.9	371.0	-	100%	Ажил бүрэн дуусаж, комиссын акт баталгаажсан.
32	НХОГ	Цэцэрлэг, сургуулиудын гадна талбайн тохижилт, ногоон байгууламж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	Барилга байгууламж	2022	2025	1,285.0	249.5	951.1	-	-	100%	Ажил хийгдэж дууссан.
33	НХОГ	Эрт ирүүлэг, оношилгооны төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	Барилга байгууламж	2022	2025	4,531.9	980.1	4,531.9	980.1	-	100%	Ажил дуусаж, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн БА-334/2025 дугаартай Комиссын дүгнэлт баталгаажсан.
34	НХОГ	Түжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцлобор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Барилга байгууламж	2023	2026	15,673.0	-	15,673.0	-	-	94%	Ажил бүрэн дуусаж, комиссын акт баталгаажих шатандаа.
35	НХОГ	Түжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцлобор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Барилга байгууламж	2023	2026	29,327.0	12,500.0	29,327.0	-	-	5%	Гэрээ цуцлагдсан.
36	НХОГ	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/	Барилга байгууламж	2018	2025	4,050.6	793.4	4,050.6	277.1	-	85%	Сургуулийн өргөтгөлийн барилгын ажил дуусаж, хүзүүвчний барилгын нэмэлт гэрээ байгуулагдсан. Хүзүүвчний барилгын цутгамал төмөр бетон каркас, гадна ханын дулаалга, гадна ханын заслын ажлууд хийгдсэн.
37	НХОГ	Ахмадын хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/	Барилга байгууламж	2022	2025	285.8	238.3	285.8	178.4	-	100%	Ажил бүрэн дуусаж, комиссын акт баталгаажсан.



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

№	Захиалагчийн нийгэмлэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	ЗГ-ын тогтоолоор барьцаа дансанд байршуулсан	Ажлын явц	Тайлбар
				Эхлэх	Дуусах							
38	НХОГ	Цэцэрлэгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	Барилга байгууламж	2024	2026	5,969.6	2,000.0	5,580.6	-	-	0%	Гэрээ байгуулагдсан. Санхүүжилт олгогдоогүй.
39	НХОГ	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 2, 30, 31 дүгээр байр/	Их засвар	2022	2025	2,694.2	594.3	2,694.2	548.2	-	100%	Ажил дуусаж, 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн ЗТ-087/2025 дугаартай Комиссын дүгнэлт баталгаажсан.
40	СХД	"Хавдар судлалын Үндэсний төв-II" барилга /Улаанбаатар/ын гадна хашааны ажил	Барилга байгууламж	2024	2025	3,000.0	-	2,620.3	-	-	5%	Гэрээ байгуулагдсан. Тодотголоор хасагдсан ажил.
41	НХОГ	Гэр хорооллын дахин төлөвлөлийн гадна цахилгааны ажлын үлдэгдэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо УИЛ бичиг хороолол/	Барилга байгууламж	2025	2027	5,134.4	500.0	5,134.4	-	-	8%	2 ком дэд өртөөний барилга угсралтын ажил, дотор тоног төхөөрөмж угсралтын ажлууд хийгдэж байна. Тухайн жилд санхүүжилт олгогдоогүй.
42	НХОГ	Багц 1 "Загвар зураг төсөв боловсруулах /Улаанбаатар"	Зураг төсөв	2025	2025	471.2	471.2	471.2	235.6	235.6	50%	Байр зүйн дэвсгэр зураг, инженер геологийн судалгааны тайлан болон эх загвар зургийг ХБХСГ-аар шинэчлэн батлуулсан.
43	НХОГ	Багц 2 "Инженерийн дэд бүтцийн ажлын зураг боловсруулах ажил /Улаанбаатар хот"	Зураг төсөв	2025	2025	221.8	221.8	221.8	221.8	-	100%	Зураг төсөв хүлээлцсэн.
44	НХОГ	Багц 3 "Гадна инженерийн шугам сүлжээний ажил, ус хангамж, ариутгах татуурга, усалгааны систем /Улаанбаатар хот"	Барилга байгууламж	2025	2025	3,850.3	3,850.3	3,850.3	1,756.1	2,094.2	46%	Замын сүлжээний ажил хийгдэж дууссан ба ус хангамжийн ф160, ф110Ф, ф63мм-ийн голчтой шугам угсралтын ажил, ариутгах татуурлын ф100мм-ийн голчтой шугам угсралтын ажил хийгдэж байна. Усалгааны системийн зураг төсөв батлагдаагүйгээс ажил удааширсан.
45	НХОГ	Багц 4 "Цахилгаан хангамж /Улаанбаатар хот"	Барилга байгууламж	2025	2025	2,233.4	2,233.4	2,233.4	2,118.9	-	95%	Ажил хийгдэж дууссан.
46	НХОГ	Багц 5 "Гадна холбоо /Улаанбаатар хот"	Барилга байгууламж	2025	2025	1,031.2	1,031.2	1,031.2	1,013.3	-	100%	Ажил дуусаж, 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ХАХО-001/2025 дугаартай Комиссын дүгнэлт баталгаажсан.
47	НХОГ	Багц 6 "Авто зам, зогсоолын ажлын зураг боловсруулах /Улаанбаатар хот"	Зураг төсөв	2025	2025	379.9	379.9	379.9	379.9	-	100%	Ажлын зураг төсвийг боловсруулж, Зам тээврийн хөгжлийн төвд 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 268/2025 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтийг хийлгэн, ажлын зураг төсвийг 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Сор-17/АХ-01 дугаартай актаар хүлээлгэн өгсөн.
48	НХОГ	Багц 1 "Хамгаалалтын хашаа /Улаанбаатар хот"	Барилга байгууламж	2025	2025	1,186.7	1,186.7	1,102.1	-	1,102.1	5%	2025.10.22-ны өдөр гэрээ байгуулагдсан. Хүитний улирал эхэлсэнтэй холбоотойгоор ажил зогссон.



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

№	Захиалагчийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ангилал	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	ЗГ-ын тогтоолоор барьцаа дансанд байршуулсан	Ажлын явц	Тайлбар
				Эхлэх	Дуусах							
49	НЗХГ	Багц 2 "Авто зам, зогсоолын ажил /Улаанбаатар хот"	Авто зам	2025	2025	10,224.4	10,224.4	10,200.9	3,630.1	6,570.9	36%	Авто замын чиг сэргээх, хар өндөр шалгуулах, ургамлын үе хуулах, экскаватороор ухмал байгуулах, далангийн дүүргэлт, суурийн доод үе, цементээр бэхжүүлсэн суурь болон авто замын хашлага, явган хүн ба унадаг дугуйн замын хашлага хавтан тавих ажлууд хийгдсэн.
50	НХОГ	Багц 3 "СОР 17 хурлын байр, байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл /Улаанбаатар хот"	Зураг төсөв	2025	2025	653.5	653.5	653.5	653.5	-	100%	Ажил дуусаж, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 12/17/2025 дугаартай актаар хүлээлгэн өгсөн.
51	НХОГ	Багц 4 "СОР 17 хурлын байр, байгууламжийн нэгдүгээр үе штын ажил /Улаанбаатар хот"	Барилга байгууламж	2025	2025	26,379.0	26,379.0	-	-	26,379.0	0%	Гэрээ байгуулагдаагүй.
52	НХОГ	Багц 5 "СОР 17 хурлын байр, байгууламжийн гадна гэрэлтүүлгийн кабель болон хамгаалалтын хоолойн урсгалтын ажил /Улаанбаатар хот"	Барилга байгууламж	2025	2025	351.7	351.7	351.7	211.0	140.7	60%	Явган зам талбайн болон гэрэлт цамхгийн тэжээлийн кабель татах, гэрэлтүүлгийн шонгийн бетон суурь хийх, гэрэлтүүлгийн газардуулга хийх ажлууд тус тус хийгдсэн.
53	НХОГ	Багц 6 "СОР 17 хурлын хүлээн авагч орны байр, нийтийн ариун цэврийн байгууламжууд, болон харуул хамгаалалтын байрны ажлын зураг төсөл боловсруулах ажил	Зураг төсөв	2025	2025	317.7	317.7	-	-	317.7	0%	Гэрээ байгуулагдаагүй.
54	НХОГ	Багц 7 "СОР 17 хурлын байр, байгууламжийн дотор төлөвлөлт, гадна, дотор болон инженерийн хангамжийн зураг төсөл боловсруулах ажил	Зураг төсөв	2025	2025	2,699.2	2,699.2	-	-	2,699.2	0%	Гэрээ байгуулагдаагүй.
55	НХОГ	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Барилга байгууламж	2025	2025	1,359.8	1,359.8	-	-	-	0%	Гэрээ байгуулагдаагүй.
НИЙТ						362,741.8	137,751.6	327,379.8	46,974.0	39,539.4		

